

Монгол Улсын 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төслүүдийн төлөвлөлт ба Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний уялдаанд дүн шинжилгээ хийх ажлын даалгавар

2026 оны 9 дүгээр сар

1. Үндэслэл

Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл УИХ-д өргөн баригдаад байна. Иймд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, анхаарах шаардлагатай асуудлуудыг олон нийтийн анхааралд оруулах, УИХ-д санал, дүгнэлт хүргүүлэх нь чухал байна.

2. Судалгааны ажлын зорилго

Энэхүү дүн шинжилгээ нь Монгол Улсын 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөтэй уялдаж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, асуудал дэвшүүлэх зорилготой.

3. Гүйцэтгэх ажил

Зөвлөх нь Монгол Улсын 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт ба Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний уялдаанд дүн шинжилгээ хийж, түүнийгээ хэлэлцүүлэг, уулзалтад танилцуулах ажил гүйцэтгэнэ.

4. Зорилтот хэрэглэгчид

Судалгааны дүнгийн зорилтот хэрэглэгчид нь бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэм байна.

5. Хүлээлгэж өгөх бүтээгдэхүүн:

Ажил гүйцэтгэгч нь дараах бүтээгдэхүүнүүдийг хуваарьт заасны дагуу ННФ-д хүлээлгэж өгнө. Үүнд:

	Бүтээгдэхүүн	Хугацаа
1	Дүн шинжилгээний эхний тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 13-ны дотор
2	Судалгааны дүнг нийтэд танилцуулах	2026 оны 10-р сарын 22-ны дотор
3	Дүн шинжилгээний эцсийн тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 25-ний дотор

6. Мэдээллийн эх сурвалж

Судалгааг хийхдээ дор дурдсан болон бусад холбогдох баримт бичгүүдийг ашиглана. Үүнд:

- Засгийн газраас УИХ-д өргөн барьсан 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө

- Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг (дэлгэрэнгүй танилцуулга, тооцоолол) болон өмнөх онуудын төсвийн гүйцэтгэлийн тайлангууд дахь төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллүүд
- Төсвийн мэдээллийн холбогдох цахим хуудаснууд
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд
- Холбогдох төрийн байгууллагууд (Сангийн яам, Хөрөнгө оруулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар гэх мэт)
- Бусад эх сурвалжууд

7. Ажил гүйцэтгэх хугацаа, төсөв:

Ажлын удирдамжийн 3-р зүйлд заасан ажлуудыг 2026 оны 10-р сарын 1-нээс 25-ны хооронд гүйцэтгэнэ.

Зөвлөх нь Нээлттэй нийгэм форумтай нягт хамтран ажиллах ба судалгааны бүтээгдхүүнүүдийг 5-р зүйлд заасан хуваарийн дагуу ирүүлнэ.

Судалгааны ажлын төсөв:

Судалгааны хүрээнээс хамаарч судалгааны төсвийн дээд хязгаар 5 сая төгрөг байна.

8. Судалгааны ажилд тавигдах бусад шаардлага, хэмжээ, хэлбэр

Гэрээт ажилд ашигласан дагалдах материал, судалгааны эх бичвэрийн файл, цахим хуудас зэргийн жагсаалтыг ажлын гүйцэтгэлд хавсаргана.